

**“ХОТЫН ИРГЭНИЙ ЖИЛ”-ИЙН ХҮРЭЭНД “НАЛАЙХЫН БАРИЛГЫН МАТЕРИАЛЫН ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК” ОНӨТҮГ-ЫН
ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

/Жилийн эцэс/

2022 оны 12 дугаар сарын 13-ний өдөр

Налайх дүүрэг

Д/ д	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хүрэх үр дүн	1-р улирлын үр дүн	Хугацаа	Хариуцах байгууллага	Хамтран ажиллах	Биелэлт /хувь/
				/I-IV улирал/			
НЭГ. ДҮРЭМ СТАНДАРТЫГ СУРТАЛЧИЛАХ ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД							
1.	4. Иргэний барилгын төлөвлөлтөд хөгжлийн бэрхшээлтэй хүний шаардлагыг тооцсон орон зай, орчны үндсэн шаардлага /MNS6055:2009/, явган хүн, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан замыг төлөвлөх заавар /MNS6056:2009/-ыг мөрдүүлж ажиллах.	Тохижилтын ажилд стандартыг мөрддөг болсон байна.	Байгууллагын гадна шатанд хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан пандус нэмэлтээр хийхээр зураг гүйцэтгэн газрын даргаар баталгаажуулсан.	I-IV улиралд	НБМҮТП ОНӨТҮГ	НЗДТГ	100
2.	9. Хог хаягдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг иргэдэд сурталчлах	Хог хаягдлын тухай хуулийн талаарх иргэдийн мэдлэг дээшилнэ.	Хог хаягдлын тухай шинэчилсэн найруулгын талаарх мэдээллийг байгууллагын албан ёсны пейж хуудсаар дамжуулан иргэдэд түгээн ажиллаж байна.	IV улиралд	НБМҮТП ОНӨТҮГ	НЗДТГ	100
ХОЁР. ХОТЫН СОЁЛЫГ ТӨЛӨВШҮҮЛЭХ ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД							
3.	12. “Иргэдийн эрх зүйн боловсрол – Хотын соёл” нэртэй пейж хуудаст мэдээлэл оруулах.	Иргэдийн хотын соёл сайжирч, хандлага дээшилнэ.	Хотын соёл, хандлагыг сайжруулах сурталчлах зорилготой мэдээ, мэдээллийг хүргүүлж ажилласан.	I-IV улиралд	НБМҮТП ОНӨТҮГ	НЗДТГ	100

4.	<p>19. Төрийн байгууллагын үйл ажиллагааны ил тод, хариуцлагатай байдлыг хангах, хяналт тавих зохицуулалтыг боловсронгуй болгох, үйл ажиллагааны нээлттэй байдлыг нэмэгдүүлж авилга үүсэх эрсдэлийг бууруулах.</p>	<p>Байгууллагын үйл ажиллагаатай холбоотой хуулиар хориглоогүй мэдээллийг иргэдэд нээлттэй, хүндрэл чирэгдэлгүй өгч байна.</p>	<p>Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн дагуу байгууллагын вэб сайт, пэйж хуудас болон мэдээллийн самбараар дамжуулан:</p> <ul style="list-style-type: none"> - Үйл ажиллагааны ил тод байдал - Хүний нөөцийн ил тод байдал - Төсөв, санхүүгийн ил тод байдал - Худалдан авах ажиллагааны ил тод байдал гэсэн дөрвөн төрлөөр мэдээ мэдээллүүдийг тогтмол болон цаг тухай бүрт нь мэдээлэн ажиллаж байна. - Авлигын эсрэг үйл ажиллагааны 2022 оны төлөвлөгөө боловсруулсан ба “Авлигын эсрэг үндэсний чуулган”-аас гаргасан зөвлөмжийг байгууллагын албан хаагчид мөрдлөг болгон ажиллаж байна. - Шилэн дансны тухай хуульд заасны дагуу байгууллагын үйл ажиллагааны нээлттэй, ил тод байдлын хүрээнд байгууллагаас гаргасан аливаа тушаал, шийдвэр, гэрээ хэлцэл, төсөв хөрөнгө захиран зарцуулах болон байгууллагын бүтэц орон тоонд орсон өөрчлөлт, санхүүгийн тайлан мэдээ, орлого, зарлага, санхүүжилт, өндөр дүнтэй гүйлгээ зэрэг бүх мэдээллийг хуулийн хугацаанд бүрэн оруулсан. Хагас жилийн байдлаар нийт 20 төрлийн мэдээг сар бүр мэдээллэсэн. 	I-IV улиралд	НБМҮТП ОНӨТҮГ	НЗДТГ	100
----	--	--	---	--------------	------------------	-------	-----

5.	20. Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын болон нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын төрийн албан хаагчдад зориулсан заавал болон сонгон суралцах сургалтын төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлэх.	Төрийн албан хаагчдын мэдлэг чадвар дээшилж, төрийн үйлчилгээний чанар сайжирсан байна.	- Байгууллагын 2022 оны хүний нөөцийн сургалт, хөгжлийн төлөвлөгөөг боловсруулсан бөгөөд заавал болон сонгон суралцах сургалтыг зохион байгуулан ажиллаж байна. - Дүүрэг, нийслэл болон холбогдох газруудаас зохион байгуулсан 12 сургалтад давхардсан тоогоор 37 албан хаагчийг хамруулсан.	I-IV улиралд	НБМҮТП ОНӨТҮГ	НЗДТГ	100
6.	22. Иргэдийн амьдрах орчныг сайжруулах ажлын хүрээнд хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгах үйл ажиллагааг идэвхжүүлэх , иргэд, аж ахуйн нэгжид чиглэсэн ангилан ялгах үйл ажиллагааны мэдлэг олгох сургалт, сурталчилгааг явуулах.	Хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгаснаар иргэдийн амьдрах орчинд хог хаягдлаас үүсэх орчны бохирдол буурна.	Байгууллагаас гарч буй хог, хаягдлыг цаас, шил лааз, хуванцар, бусад гэж 4 ангилан ялгаж хэвшил болгосон бөгөөд паркийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдэд сурталчлан таниулж нэвтрүүлэх ажил хийгдэж байна.	I-IV улиралд	НБМҮТП ОНӨТҮГ	НЗДТГ	100
7.	32. Гудамж талбай олон нийтийн газар, цахим орчинд олон нийтийг үл хүндэтгэж зүй бус үг хэллэг хэлэх, шүлс, нус цэрээ хаях, шээх, зориулалтын бус газар тамхи татах, тамхины иш, хог хаягдлыг хаях, садар самуун үг хэллэг, үйлдэл гаргах асуудлын эсрэг иргэд, ААНБ, бүх төрлийн байгууллагын ажилчдын хүчээр тэмцэх, үлгэрлэх, соён гэгээрүүлэх ажлыг тууштай үр дүнтэй зохион байгуулах.	Хүүхэд залуусыг зөв, шударга, эерэг хандлагаар үлгэрлэн, олон нийтийн, харилцаа, хандлага ахиц гарч, бусдын эрхийг ,ашгийг хүндэтгэх найрсаг хандлага бий болсон байна.	Албан хаагчийн ёс зүйн дүрмийг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан ажлын байрны цаг ашиглалт, сахилга, дэг журмыг сайжруулах ёс зүйн хороог ажиллаж байна.	II-IV улиралд	НБМҮТП ОНӨТҮГ	НЗДТГ	100

ГУРАВ. ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ, ОРЛОГО НЭМЭГДҮҮЛЭХ ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД

8.	38. Барилгын материалын үйлдвэрлэл, технологийн парк, Багануур үйлдвэрлэл технологийн парк, Эмээлтийн хөнгөн үйлдвэрийн үйлдвэрлэл, технологийн парк, Багахангай үйлдвэрлэл, технологийн паркуудын дэд бүтцийг байгуулах.	Паркуудын дэд бүтцийг байгуулсан байна.	<p>- НБМҮТП-ийн үндсэн цахилгаан хангамжийн бүтээн байгуулалтад 2022 онд нийслэлийн төсвөөс 3,577.3 сая төгрөг тусгагдсан бөгөөд төсвийн тодотголоор 1,000,0 сая төгрөг нь хасагдсан. Үндсэн цахилгаан хангамжийн ажлыг гүйцэтгэгч “Вилл вест” ХХК нь “110/10 кВ-ын дэд станцын ил хуваарилах байгууламжийн өргөтгөл”-ийн тоног төхөөрмжийн суурь, “10 кВ-ын кабель шугамын угсралт”-ын ажлыг бүрэн дуусгасан. “10 кВ-ын хуваарилах байгууламж”-ийн тоноглолын угсралт, суурилуулалтын ажил болон 1,000.0 сая төгрөгийн тоног төхөөрөмж, материалын захиалга хийн татан авалтын ажлуудыг хийж байна.</p> <p>- 1000 м3 цэвэрлэх байгууламжийн хөрөнгө оруулалтыг “Европын сэргээн босголт, хөгжлийн банк”-ий санхүүжилтээр гүйцэтгүүлэх санал хүргүүлээд байна.</p> <p>- 26 МВт-ийн дулааны станцын хөрөнгө оруулалтыг барилга хот байгуулалтын яамны 2023 оны төсвөөр гүйцэтгүүлэхээр санал хүргүүлээд байна.</p> <p>- ҮТП-ийн дэд бүтцийн ажлуудын гадна цахилгаан хангамжийн ажлын зураг төслүүдийн хөрөнгө оруулалтыг шийдвэрлүүлэхээр НЗДТГ, БХБЯ болон холбогдох газруудад хүсэлт гаргасан.</p> <p>- 2022 онд парктай гэрээ байгуулсан 2 аж ахуйн нэгж бичиг баримтын бүрдэл хангагдан үйлдвэрийн бүтээн байгуулалтын ажлаа эхлүүлсэн бөгөөд барилга</p>	I-IV улиралд	НБМҮТП ОНӨТҮГ	НЗДТГ	100
----	---	---	---	--------------	------------------	-------	-----

			<p>угсралтын ажил 30%-та явагдаж байна.</p> <p>- “Таван толгой түлш” ХХК-ийн зүүн бүсийн үйлдвэрийг усаар хангах усан хангамжийн байгууламж, усан сан, гүний худгийн барилга байгууламж, шугам хоолойн угсралтын ажлын бүтээн байгуулалтыг эхлүүлэх ажлын хүрээнд паркийн 120 га газар дээр байгуулах 2 ширхэг гүний худгийн ерөмдлөгийн ажил хийгдэж дууссан. 2 худгийн барилгын ажил хийгдэж байна. “ТТТ” ХХК-руу татах 6.3 км шугам хоолойн газар шорооны ажил хийгдэж байна.</p> <p>- Барилга хот байгуулалтын сайдын 2020.09.07-ны өдрийн 169 дугаар тушаалын дагуу паркийн өргөтөл 130 га газрын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг боловсруулах зөвлөх үйлчилгээний сонгон шалгаруулалт явагдаж 228.8 сая төгрөгөөр “Өрх” ХХК 2021.01.28-ны өдөр 2021/47 дугаар гэрээ байгуулан ажиллаж гүйцэтгэл дууссан ба мэргэжлийн зөвлөлийн дүгнэлт болон магадлал хийлгэх ажлууд хийгдэж байна.</p>				
ДӨРӨВ. АМЬДРАХ ОРЧНЫГ САЙЖРУУЛАХ ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД							
9.	69. “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд айл өрх, ААНБ-ыг идэвхтэй оролцуулах, ногоон байгууламжийг нэмэгдүүлж, арчлалт хамгаалалтын менежментийн ажлыг сайжруулах.	Иргэдийн оролцоо сайжирч, ногоон байгууламжийн тоо нэмэгдсэн байна.	<p>- 2022.05.14-ний өдөр Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг хэрэгжүүлэх, иргэдэд мод тарих соёлыг сурталчилан түгээх ажлын хүрээнд “Шинэ-Налайх” цэцэрлэгт хүрээлэнд “Ногоон хот-Иргэний оролцоо” мод тарих арга хэмжээний нээлтийн үйл ажиллагаа болж өмнөх онд тарьсан мод сөөгний арчилгаа, тордолтыг хийж, энэ онд тарих модоо</p>	II-IV улиралд	НБМҮТП ОНӨТҮГ	НЗДТГ	100

			<p>суулган, байгаль дэлхийгээ хайрлан хамгаалах ажлыг эхлүүлсэн.</p> <p>- 2022.05.19-ний өдөр Налайх дүүргийн зүүн чиглэлийн автозамын А/24 постноос Хөнгөн блокны үйлдвэр хүртэл зам дагуу 130 ширхэг хайлаас, 10 ширхэг улиас модны суулгацыг тарьж усалгаа арчилгааг хийн цэцэрлэгжүүлэлтийн албанд хүлээлгэн өгсөн.</p> <p>- 2022.10.13-ны өдөр “Тэрбум мод” хөтөлбөрийн хүрээнд НБМҮТП-ын албан хаагчид А/24 постноос хөнгөн блокны үйлдвэр хүртэлх зам дагуу тарьсан улиас, хайлаас моддын намрын цэнэг усалгааг Цэцэрлэгжүүлэлтийн албатай хамтран хийж гүйцэтгэсэн.</p>				
10.	70. Нийтийн эзэмшлийн гудамж, талбайн сул шороон хөрсийг зүлэгжүүлж, тоосжилтыг бууруулах арга хэмжээ авч ажиллах.	10000 м.кв-аас багагүй талбайг зүлэгжүүлнэ.	Байгууллагын урд талын 750 м.кв талбайг зүлэгжүүлж шинээр 10 улиас мод суулган арчилалт усалгааг тогтмол хийж байна.	II-III улиралд	НБМҮТП ОНӨТҮГ	НЗДТГ	100
ТАВ. ЭРҮҮЛ МЭНДИЙГ АНХААРАХ ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД							
11.	84. Халдварт бус өвчний эрт илрүүлэг, оношилгоо, эмчилгээг сайжруулах.	Халдварт бус өвчний урьдчилан сэргийлэх үзлэгийн хамрагдалтыг нэмэгдүүлж, эрт үед нь эмчилсэн байна.	2022 оны төсөвт ажилтан, албан хаагчдыг урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээнд хамруулах төсөв тусгагдаагүй тул албан хаагчдыг НД-ийн хөнгөлөлтөөр эрт элрүүлэг шинжилгээнд хамрагдах нөхцөл бололцоогоор ханган ажиллаж байна. Одоогийн байдлаар 2 албан хаагч бүрэн хамрагдаж, шинжилгээний үр дүнгийн дагуу эмчилгээ хийлгэж байна.	I- IVулирал д	НБМҮТП ОНӨТҮГ	НЗДТГ	100
12.	86. Иргэдийн нийтийн биеийн тамир, спортоор хичээллэх орчин нөхцөлийг сайжруулах.	Иргэд эрүүл амьдралын хэв маягт суралцаж, дасгал хөдөлгөөнөөр	- Байгууллагын спорт хамтлаг 2022 онд төлөвлөгөөний дагуу ажилласан.	I-IV улиралд	НБМҮТП ОНӨТҮГ	НЗДТГ	100

		хичээллэгсдийн тоо нэмэгдсэн байна.	<p>- Зэвсэгт хүчний 350 дугаар ангитай хамтран ажиллаж сар бүр тогтсол спортоор хийллэдэг.</p> <p>- Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн санаачилсан “Алхацгаая, гүйцгээе” хөдөлгөөний хүрээнд албан хаагчдын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, хөдөлгөөний дутагдлаас сэргийлэх, түүх, дурсгалт газруудтай танилцах зорилтын дор зохион байгуулж Налайх-Төв аймаг маршрутаар явган аялалыг удирдамжийн дагуу явуулсан.</p> <p>- 4 дүгээр улиралд зохион байгуулах 3 төрөлт спорт тэмцээнийг спорт хамтлагийн төлөвлөгөөний дагуу явуулах бэлтгэл ажлыг хангаж байна.</p>				
ЗУРГАА. АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД							
13.	122. Гамшгаас хамгаалах иж бүрэн сургуулийг 2 дүүрэгт зохион байгуулах.	Налайх, Сүхбаатар дүүрэгт Гамшгаас хамгаалах иж бүрэн сургууль зохион байгуулж, гамшгаас хамгаалах чиглэлээр мэдлэг, ур чадвар дээшилж, бэлтгэл бэлэн байдал хангагдсан байна.	<p>- НБМҮТГ” ОНӨТҮГ-азрын гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулан, Гамшгаас хамгаалах орон тооны бус штабыг байгуулан Налайх дүүргийн онцгой байдлын хэлтсээр зөвшөөрүүлэн хэрэгжилтийг ханган ажиллаж байгаа бөгөөд 2022 оны 2 дугаар улиралд Налайх дүүргийн Онцгой байдлын хэлтсээс “Гамшиг ослын үед хэрхэн ажиллах шаардлагатай мэдээллийг авах, газар дээрээ ямар арга хэмжээг зохион байгуулах” мэдээлэл, сургалт авах дадлага зохион байгуулсан.</p> <p>- Байгууллагын нөөц бололцоогоор 2 сая төгрөгөөр галын сарайг хийсэн.</p>	II-IV улиралд	НБМҮТГ ОНӨТҮГ	НЗДТГ	100
14.	128. Барилгын орчны аюулгүй байдлыг хангах талаар нийслэлийн хэмжээнд үйл	Нийслэлийн иргэдийн амьдрах орчны	Паркт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдэд барилгын норм, дүрэм, тавигдах шаардлагын	I-IV улиралд	НБМҮТГ ОНӨТҮГ	НЗДТГ	100

<p>ажиллагаа явуулж буй барилгын компаниудын үйл ажиллагаанд хяналт тавьж барилгын норм, дүрэм, тавигдах шаардлагын хэрэгжилтэд хяналт тавьж зөрчлийг арилгах талаар холбогдох байгууллагуудтай хамтран ажиллана. /Барилгын гадна түр хашаа, хаалт, хашлага, хүрээ гэх мэт/</p>	<p>аюулгүй байдал хангагдана.</p>	<p>хэрэгжилтийн хяналт тавьж ажиллаж байгаа бөгөөд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн анхан шатны сургалтад байгууллагын нийт албан хаагчид хамрагдаж анхан шатны мэдлэг эзэмшсэн.</p>				
---	-----------------------------------	---	--	--	--	--